

**ХОРЧИН АМАН АЯЛГУУНЫ СОЁЛЫН ОРЧИН АХУЙ БА
ХЯТАД ЗЭЭЛЛЭГ ҮГИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ**

Б. Юн Фан*
Б. Мань Лян*

Агуулгын товч: Тус өгүүлэлд өмнөх хүмүүсийн судалгааны суурь дээр, хэл шинжлэлийн тодорхойлох арга, харьцуулах арга, жич бүртгэлийн онол аргаар, Хорчин аман аялгууны өвөрмөц соёлын орчин ахуй жич Хорчин монголчуудын хэл ярианд үүссэн хувиралтын тухай өгүүлж, Хорчингуудын өдөр тутмын амьдрал ба ардын дуу, хэвшмэл хэлц дэх хятад зээллэг үгсийн хэрэглээний байдал ба авиа бүтэц талаарх монголжсон онцлогийн тухай тоочин өгүүлжээ.

Хорчин аман аялгуу бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын монгол хэлний аялгуу, аман аялгууны дотор хэрэглэгдэх хүн амаар хамгийн олон, нөлөө ихтэй нэгэн аман аялгуу болно. Хэл аялгууны нийгмийн үйлдэл, хэрэгцээ ба хэлний дүрэмжил хөгжил, монгол соёл, хэл шинжилгээний үүднээс үзсэн ч, Хорчин аман аялгуу нь судлууштай, сонирхолтой нэгэн чухал аман аялгуу болох бөгөөд энэ талаар анхаарч судлах нь маш ач холбогдолтой юм.

Монгол хэлний нутгийн аялгуу, аман аялгууны бүрэлдэл нь урт удаан түүхэн цаг үеийг өнгөрүүлсэн байна. Хорчин аман аялгуу бол монгол хэл аялгууны дотор хөгжилт хувиралтаар онц түргэн нэгэн аман аялгуу болно. Түүний бүрэлдэл хөгжлийн ард будлиантай нийгмийн ахуй байдал байдаг. Газар зүйн байршил жич нийгэм түүхийн бусдач шалтгаанаас болж, Хорчин аман аялгуунд нэлээд хэмжээний хятад зээллэг үг орж иржээ. Хорчины түүх соёл ба түүний өвөрмөц нийгэм ахуй жич үүнээс шалтгаалсан хэлний хувьсал хөгжлийн асуудлыг судлах нь Хорчин аман аялгууны судлалд чухал ач холбогдолтой.

Одоо үед, Хорчин аман аялгууны судлалын талаар тодорхойлсон хэлшинжлэлийн үүднээс судалсан бүтээл өдий төдий гарч байна. Жишээлбэл: Баянцогтын найруулсан “Хорчин аман аялгууны судлал”, Цагаанхадын найруулсан “Монгол хэлний Хорчин аман аялгууны судлал” гэх мэт. Эдгээр бүтээлд Хорчин аман аялгууг авиа, хэл зүй, үгсийн сангийн талаар ерөнхийлөн судалж, нэлээд нарийн тайлбарласан байна.

* Б.Юн Фан, Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн Монгол хэл, утга зохиолын салбарын 2011 оны хэлшинжлэлийн чиглэлийн аспирант.

* Б.Мань Лян, Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн Монгол хэл, утга зохиолын салбарын доктор, профессор, Монгол хэл аялгуу ба Алтай хэлний харьцуулсан судлалын чиглэлээр судалгаатай.

Бидний анхаарснаар, хятад зээллэг үг Хорчин аман аялгууны өдөр тутмын амьдралд гүн нэвчсэнээр барахгүй, Хорчин ардын аман зохиол, урлаг соёлын хэлбэрт ч нэлээд хэмжээгээр шимтэн орж, өвөрмөц онцлог бүхий аялгууны соёл бүрэлдэн тогтсон байна. Бодтойгоор яривал, одоох Хорчин ардын дуу, хуурын үлгэр, Хорчины ардын зүйр цэцэн үг зэрэгт хятад зээллэг үг маш арвин нэвчиж орсон. Иймээс бид тус өгүүлэлд Хорчин аман аялгууны өвөрмөц соёлын орчин ахуй, хятад зээллэг үгийн хэрэглээний байдал, Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үгийн онцлог жич түүний хөгжил хувирлын тухай өгүүлэх болно.

Хятад ард улсад, Хорчин аман аялгуу буюу Хорчин соёл судалгаанд холбогдсон өгүүлэл, зохиол өдий төдий гарч байна. Жишээлбэл, Баянцогтын *“Хорчин аман аялгууны судлал”* (*хэвлэлийн хороо ба хэвлэгдсэн он зэрэг мэдээг ашигласан ном зохиолын хэсэгт*) тодорхой хадсан тул энд товчлов, доош адил), Тэтгэ. И.Хайрхан, Эрдэмт, Б.Сод нарын *“Хорчин аман аялгуу ба орон нутгийн соёл судлал”*, Тулгуур, Б.Сод эрхлэн найруулсан *“Хорчин аман аялгууны хувирал хөгжлийн судлал”*, В.Сэцэн *“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн товчоо”*, Баянцогтын *“Нутгийн аялгууны шинжлэл”*, Сэцэн эрхлэн найруулсан *“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл”*, Сэцэнбаатар эрхлэн найруулсан *“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн удиртгал”*, М.Баатар, Б.Содын эрхлэн найруулсан *“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл”* зэрэг тусгай бүтээл ба их дээд сургуулийн хичээлийн бичиг хэвлэгдсэн байна. Эрдэм шинжилгээний өгүүлэл, зохиолоос гол хэдийг дурдвал, Төвийн Үндэстний Их Сургуулийн Б.Содын доктор цол хамгаалсан өгүүлэл *“Монголын хэлний Хорчин аман аялгууны үгсийн сангийн судлал”*, Хүрэлшаа *“Хорчин зан үйлийн соёл судлал”*, Хурц, Чан Мин-гийн *“Хорчин товчоон”* гэх мэтийн ном ба Б. Сод *“Монгол хэлний Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үг”*, Э. Хишигт *“Хорчин аман аялгууны зарим онцлогийн тухай өгүүлэх нь”*, Мандалаа *“Хорчин ардын дуун дахь хятад хэлний нөлөөлөл”*, Б.Сод *“Тариалах соёл ба Хорчин аман аялгуу”*, Эрхэмбаяр *“Хорчины газар усны нэрийн домог дахь хятад соёлын нөлөө”*, Б.Сод *“Хорчин соёл судлалд холбогдох зарим асуудал”*, Т.Хасбаатар *“Монгол хэлэн дэх хятад зээллэг үгийн асуудалд”*, Зандан *“Нийгэм хэл шинжлэлийн хараанаас Хорчин аман аялгуун дахь монгол, хятад холимог хэллэгийн буй болсон шалтгааныг сүвэгчлэх нь”* гэх мэтийн өгүүлэл харагдана.

Үүнд: Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Хүрээлэнгийн профессор Баянцогт багшийн найруулсан *“Хорчин аман аялгууны судлал”* номд, хэлшинжлэлийн тодорхойлох аргаар, Хорчин аман аялгууны авиа, үгзүй, өгүүлбэр зүй, үгсийн сангийн зүй болон үг хэллэгийн материал зэрэг талаар нэлээд системтэй тайлбарласан байна. Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үгсийн ерөнхий байдлыг үгсийн аймгийн ялгалаар төрөл хувааж танилцуулсан нь амжилттай тал болно. Б.Содын доктор цол хамгаалсан өгүүлэл *“Монгол хэлний Хорчин аман аялгууны үгсийн сангийн судлал”*-д, хээрийн байцаалтын материал ба сурвалж бичгийн материал жич нэгэнт олсон судалгааны үр бүтээлд суурилан, нийгэм, түүх ба соёлын ахуй байдал зэрэг талаас Хорчин аман аялгууны үгсийн сан дахь гүнзгийрэн судлагдаагүй зарим асуудал, жишээлбэл: үгийн гарал үүслийн талаар улам нэг алхам шинжилгээ хийжээ. Б.Содын бас нэг *“Монгол хэлний Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үг”* гэх өгүүлэлд, Хорчин аман аялгууны үндсэн үгсийн сан дахь хятад зээллэг үгийн тухай задлан шинжилж, хятад зээллэг үгийн авианы онцлогийг Цахар аман аялгуу болон бичгийн хэлний авиатай харьцуулсан бөгөөд хятад зээллэг үгийн Хорчин аман аялгуунд

үзүүлсэн нөлөө нь Цахар аман аялгуу болон бичгийн хэлэнд үзүүлсэн нөлөөнөөс хол илүү гэх үзэлтийг дурджээ.

Өнгөрсөнд, авиа зүй, хэл зүй, үгсийн сангийн аль нэг тал буюу бүх талаас тодорхойлон шинжилсэн зохиол зонхилох байрыг эзэлж, харьцуулсан судалгаа буюу олон хараат ерөнхийлсөн судалгааны бүтээл цөөн байна. Хорчин ардын дуу, Хорчин ардын зүйр цэцэн үг мэтийн Хорчины өвөрмөц урлагийн хэлбэрт шингэсэн хятад зээллэг үгийн нөлөө, тоо нормыг анхаарч судалсан зүйл хараахан харагдаагүй байна. Бас Хорчины ярианы хэлний үзэгдлийг оновчтой таньж шинжлэх талаар, жич Хорчин аман аялгууг бичгийн хэл ба бусад аялгуу, аман аялгуутай харьцуулан шинжих талаар, Хорчин аман аялгуу болон хятад хэлний харьцаа, хятад зээллэг үгийн хувирал хөгжлийн талаар, үгсийн сангийн баялаг нөөцийг уудлах талаар судлуудтай асуудал, ажил олон буй.

Нэгдүгээр бүлэг

Хорчин аман аялгууны өвөрмөц соёлын орчин ахуй

Одоогоос зуу гаруй жилийн өмнө хүртэл, Хорчин нутаг нь ус тунгалаг, өвс соргог, нүд алдам ногоон байгальтай байсан. Тэр үед Хорчингууд усны тунгалаг, өвсний соргогийг дагаж, элбэг баялаг байгаль ахуйдаа зохицон, уламжлалт ёсоор нүүдэл иргэншлийн амьдрал хийж байсан. Гэтэл өнөө үед, Хорчин нутагт айл тосгон залгалдан, бага дунд хот балгас холболдож, хүн ам нягтарч, тариалах соёл голлосноос, нүд алдам ногоон бэлчээр байтугай, уулын орой, гуу гангад хүртэл тариан газар болж хагалбарлагдаад, тархан бэлчээрлэсэн таван хошуу мал сүрэг өдрөөс өдөр цөөдөж, Хорчины түүхэнд урьд өмнө гараагүй аж ахуйн хувьсал болжээ.

Нэгдүгээр хэсэг. Малжих ба тариалах соёлын орчин ахуй

Нүүдэл мал аж ахуй ба тариалан аж ахуй нь хоёр ондоо аж ахуйн соёлын суурь болно. Хоёулын хэл аялгуунд үзүүлэх нөлөө нь ч адилгүй. Монголчуудын уламжлалт нүүдэл малжилын амьдрал бол хэлний нэгдэлд ашигтай байжээ. “Монголчууд нь өнө удаан жил нүүдлийн мал аж ахуйг эрхлэн аж төрсөөр ирсэн учир нутгийн аялгууны хоорондын ялгаа асар их бус бөгөөд аль хойно орших Сэлэнгийн Буриадууд, Хатан голын цаана орших Ордосынхонтой саадгүй харилцах жишээтэй байдаг”¹. Үүнтэй эсрэгээр тархай бутархай нийгмийн орчин ахуйд бол суурьшмал тариалан аж амьдрал нь хэлний задралыг түргэтгэдэг байжээ. Тариалах нь нүүдэл малжилтай адилтгавал харьцангуй тогтвортой чанартай байж, хүмүүс тогтмол газар нутгаа сахиж, үе улиран аж төрөн амьдардагаас эл аялгуу, аман аялгууны хоорондох ойртолцоо ба нөлөөлөлцөө аяндаа багасч, тухайн аялгуу, аман аялгуу нь харьцангуй тусгаарласан орчинд өвөрмөц онцлогтой хөгжих нөхцөл бүрэлддэг².

Хорчингууд XIX зуун болтол бараг л нүүдлийн мал аж ахуй эрхэлж, урьд хожид Ноон мөрний урсгал дагуу орон, Ляодунгийн хил хязгаар, дээд Шар мөрний урсгал дагуу орон, хоёрдугаар Сунгари мөрний ам дагуу орныг багтаасан өргөн уудам газраар

¹ tedke, qayirqan, erdemtū, sodu, (2001) *qorč'in aman ayalyu ba oron nutuγ-un soyul sudulul*, p-137. liyooning-un ündüsüten-ü keblelün qoriy-a.,

² tedke, qayirqan, erdemtū, sodu, (2001) *qorč'in aman ayalyu ba oron nutuγ-un soyul sudulul*, p-137. liyooning-un ündüsüten-ü keblelün qoriy-a.,

нааш цааш нүүдэллэн явж, орчин тойрны бүх аймаг угсаатай элдэв харьцаа гарч байснаас, хэл ярианы талаар тийм их өвөрмөц онцлогтой болоогүй байжээ. Харин хэзээ сүүлээр нь тэд малжихын дагуу тариалан аж ахуйг эрхэлж, цаашлаад зарим газар нь тариалах орон болж хөгжсөнөөс, соёлын талаар бусад орноос ялгаатай болоод хэл, ярианд нь ч нэлээд их зөрүү гарч эхэлсэн байна³.

Байгаль, орчин тойронд зохилдох талаар уулын Хорчингуудын нүүдэл малжилын амьдрал нь байгалийн орчинд бүрмөсөн түшиглэж, түүний жам ёсыг журамлаж байснаас, хүн болон байгаль дээд хэмжээгээр зохицолдон, байгалийн орчин ахуй ч үндсэндээ тэр хэвээрээ хадгалагдаж ирсэн билээ. Отор нүүдлийн амьдралын онцлогоос болж, малчид зөвхөн байгальд зохицолдохоор чармайхаас биш байгалийн ус өвс, ургамал мод, онцгойлон хөрс шороо эвдэхийг чанга сэргийлэх зан аалтай болж дадсанаас, чадах хэрээрээ газар нутгаа хамгаалах явдалд оролцдог. Атар хагалбарлагдсанаас сүүлээр, Хорчин нутгийн байгалийн орчин ахуй идэг идгээр эвдэгдэж, газар нутаг элсэрхэгжиж, шинээр буй болсон монгол тариачин нь хятад тариачныг дуурайн, олон зүйлийн эд гаралтаа хүч чинээгээр малтаж, хүн болон байгаль зохицолдох хэмээ алдах хандлагатай болж байна.

Малжихаас тариалахад шилжилтийн үе буюу хагас малжих, хагас тариалах хоёрдмол аж ахуйн хэлбэр бий болдог. ...Орон нутаг бүр түүний аж амьдралын өвөрмөц байдлыг тусгасан үг хэллэгтэй.⁴ Холимог аж ахуйн хэлбэр маяг нь хэл ярианд шууд тусч, Хорчин аман аялгуунд шинэ элемент нэмж, түүнийг улам их өвөрмөц онцлогтой болгон хөгжүүлжээ.

Хорчингуудын үг хэлний талаар, уулын нүүдэл малжилын холбогдолтой үгсийн дээр тариалах соёлын онцлог бүхий үг хэллэг нэмэгджээ. Тухайлбал, уулын эмээл хазаар, ус бэлчээр, малын тарга хүч, морины сургал, гүйдэл зэрэг малжих амьдралын өдөр тутмын үгсийн дагуу, анжис хошуу, алчуур хадуур, далан жороо, үтрэм зэрэг тариалах аж ахуйн үгсийг ч хэлэх болжээ. Тариалах аж ахуйг эрхэлсэн нь, Хорчин нутагт бөөнөөр ирж суурьшсан хятдуудын авчирсан зүйл болохоор, Хорчингууд тэдний амьдралын агуулга хэлбэрт нь нөлөөлөгдөхөөр барахгүй, хэл соёлд нь ч нөлөөлөгдөж билээ.

Хорчин аман аялгууны зарим үгст утгын хувирал гарч буй. Жишээлбэл: тариалах оронд үхрийг голдуу анжис буюу тэргэнд хөллөдөгөөс Хорчины зарим газарт үхрийг *мал* гэж, хөлсний үхрийг харин *үхэр* гэдэг. Тэгээд *мал* гэх үгэнд нь ч *үхэр* гэдэг салбар утга нэмэгдсэн байна. “*бүдүүн, том, их, бага, цөөн, жаахан, сайн, муу*” гэх мэтийн монгол хэлний үндсэн үгсийн оронд “*лаоди, сяоди, няоди, лайди*” гэж хятадаар илтгэх хүмүүс бага бус болжээ. Хүний нэр дуудлагад хүртэл хятад, монгол нэр зөндөө байгааг юун өгүүлэх. Хорчины монгол тариачид замд уулзаж ярилцахдаа: - Тариа төмс хэр зэрэг?, Ус бороо ямар вэ? гэж асуулцдаг болжээ. Эдгээр нь бүр аж ахуй соёлын хэлбэр нь хэл аялгууны хувирал хөгжлийн шалтгаан болохыг тод харуулж байна.

³ tedke, qayirqan, erdemtū, sodu, (2001) *qorč'in aman ayalγu ba oron nutuγ-un soyul sudulul*, p-137. liyooning-un ündüsüten-ü keblelün qoriy-a.,

⁴ tedke, qayirqan, erdemtū, sodu, (2001) *qorč'in aman ayalγu ba oron nutuγ-un soyul sudulul*, p-138. liyooning-un ündüsüten-ü keblelün qoriy-a., Тус өгүүлэл дэх Хорчин ардын дуу ба зүйр сэцэн үгийн жишээнүүдийг *Хорчин ардын дуу*, I, II ба *Хорчин ардын зүйр үг ба хавт үгийн эмхэтгэл*, зэрэг номоос ашигласан байна. Жишээнд холбогдох нүүрийн дугаар хэт олон тул жишээ түс бүрт зүүлт хадахыг товчилсноо энд тодорхойлъя.

Хоёрдугаар хэсэг. Тариалах соёлын орчин ахуй ба хэл аялгуу

Хорчингуудын тариалах аж ахуйг эрхлэх болсон нь Хорчин аман аялгууны хувиралыг түргэтгэсэн чухал шалтгааны нэг болно.

Нэг. Тариалахын хамгийн их онцлог нь нутагшил болно. Нутагшлын үр дүнд, хүн амын тоо түргэн нэмэгдэв. Одоо Хорчин аман аялгуугаар ярилцагч хүн зуу илүү түмд хүрч, бүх монгол хэл аялгууны дотор хамаг олон хүн амтай аман аялгуу болсон.

Суурьшмал аж ахуй нь бүхий л нийгмийн амьдралыг баяжуулсан байна. Хорчин бол монгол үндэстний доторх аж үйлдвэр, арилжаа худалдаа ба соёл, сурган хүмүүжил их хөгжсөн орны нэг болно. Энэ нь ч хэл ярианд бүрэн тусгалаа олдог. Одоо Хорчины нэлээд газарт хятад, монгол холилдон сууж байгаа буюу зарим газрын хятадуудын тоо нэмэгдэхийг дагалдан, Хорчингуудын хэлээ алдах хэм хэмжээ ч өндөр болж байна. Ялангуяа хот балгасны Хорчингуудын эх хэлээ хаяж байгаа байдал хүнд ноцтой болов. Үүнийг тариалах соёл, хятад соёл хоёрын хөгжлийн үр дүн гэж үзэж болно.

Хоёр. Тариалах соёлын шалтгаанаас, Хорчингууд эд бодос, хэрэглээнд хандах талаар тариалах үйлдвэрлэлийн зогсолтоос асуудлыг үзэн задлах болжээ. Тухайлбал, нүүдэл малжилын амьдралын үед моринд онц хайр бахтай байж, морийг шинжихдээ дэл сүүл, чих нүд, туурай, биеийн хэлбэр байдлын зохицолдол, гүйдэл зэргийг сонирхож, чухалчилж байсан бол тариалах соёлын үе болж ирэхэд, хүч дорвитойг л чухалчлах болжээ.

Гурав. Тариалах оронд хүний харьцаа нэн будлиантаж хөгжсөн байдаг. Хүний харьцааны нягтрал хөгжил нь аяндаа хэлний харилцааны үйлдлийг улам их болгож, хэлний хувиралыг түргэтгэдэг. Иймээс Хорчин аман аялгуу нь зарим талаар бусад аялгуу, аман аялгуунаас түргэн хувирсан байна.

Дөрөв. Соёлын амьдралын талаар, орчин үед Хорчин монголчууд өөрийн онцлог бүхий өнөр баялаг соёлыг үүдэж, хойч үедээ үлдээн өвлүүлсэн юм. Бидний мэдээжээр орчин үед Хорчин нутагт, түүхэн хэрэг учир олширсон ба ширүүссэнээс болж, элбэг агуулгатай цаг үеийн онцлог бүхий Хорчин ардын дуу онц арвин зохиогдсон билээ. Үүнд: дарлал мөлжлийг эсэргүүцсэн, чөлөөт янагийг хүсч мөрөөдсөн, муу муухайг хошигнож шоглосон зэрэг олон талын агуулгыг хамарчээ.

Хуурын үлгэр нь ч Хорчин нутгийн тариалах орны өвөрмөц соёлын орчин ахуйд бүрэлдсэн урлагийн хэлбэр болно. Тариачин айлынх нь ямар нэгэн баяр дурсгалыг бэлгэлэх буюу буян үйлдэх эсвэл гацаа тосгоноос олон түмний амьдралыг харгалзах (яриангүй айл гэрийнх нь шууд сонсох дуртайгаас шалтгаалах) үед хуурч залж үлгэр яриулдаг. Голдуу хятадын эртний үлгэрийг монголоор ярина. “Гурван улсын үлгэр”, “Сүй Тан-ийн үлгэр”, “Шүй хо-гийн үлгэр” гэх мэт. Ярихдаа, дөрвөн утаст хуур татаж, үлгэрийнхээ агуулгыг ярих ба дуулахыг уялдуулдаг. Хуурын үлгэр нь голдуу тариалангийн ажлын сул сэлүү цаг, олонхдоо өвлийн шөнө, үдшийн цагт эхэлдэг. Зарим үлгэрийг нэг сар буюу хоёр сараар хэлдэг. Үлгэр нь Хорчин ардад сайн сайхныг ухуулж, муу муухайг тэвчдэг нийгмийн ёсыг таниулж байснаар барахгүй, уул үлгэр дэх хятад соёлын үзэгдэл, хэл хэллэгийг ч маш олон уламжилжээ.

Хоёрдугаар бүлэг

Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үгийн хэрэглээний байдал

Нэгдүгээр хэсэг.

Хятад зээллэг үг Хорчин ардын өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгдсэн нь

Нэг. Хорчин аман аялгуунд, тариалан аж амьдралын тухай үгсээр баялагжсан бөгөөд үүнийг дагалдан, хятад зээллэг үг ч олон орж иржээ. Янсуур, бангуу, зээтүү гэх мэт олон нэр үгс бий.

Хорчин аман аялгууны таримал, идээ ундааны нэр, идээ ундаа боловсруулах, өдөр тутмын зардал хэрэгслийн нэрд холбогдох хятад зээллэг үгсээс бодтой жишээ үзье: sandu: 钎刀- альс цохиход хэрэглэдэг урт иштэй хутга, bangō: 板镐- нимгэн иртэй гуурс малтах багаж, tō:baŋs 套脖子- морь, луус, илжигний хүзүү шөргөөгдөхөөс хичээж, эсгий арьсаар баглаж хийсэн хүзүүвч, ja:fēŋ 埡厢-тэрэгний арлын дээд талын хашууртай хэсэг, ʃa:fīŋ 煞绳- хадсан тариа буюу өвс, түлээ зэрэг тэрэгний тээшийг дарж эрэх бүдүүн дээс, goaŋʃa: 铁锹-төмөр хүрз, sanʃa: 三叉-шавраар хэрэм босгоход хэрэглэдэг гурван салаат багаж, əʃis 二齿子-шавар нухах буюу гохдох хоёр шүдэт багаж, ʃa:du: 铡刀- өвс хэрчих багаж, bō:du: 薄刀- тогоон гэрт мах, ногоо хэрчихэд хэрэглэдэг хутга, ma:dē: 麻袋 – химийн ширхэгээр нэхсэн бүдүүн хүүдий, ʃa:baŋs 夹板 –морь, илжигний хүзүүнд тохдог, туугийн үзүүрийн зүтгүүр буюу (хавчуур) мод, dō:dē: 肚带-унааны гэдсэн доогуур татдаг дайс, anʃu: 安头的 - унаганы толгойд зүүлгэж, амыг битүүлдэг хэрэгсэл, ʃamxa:n 厢房 - гол гэрийн өмнө талд хоёр гарлан барьсан гэр, bē:lmē: 苞米 - эрдэнэ шиш, mē:s 麦子 - буудай, pa:du: 巴豆 - чанаж иддэг бор эрээн буюу улаан буурцаг, dō:s 稻子 - тутрага, xuaŋdu: 黄豆 - шар өнгөтэй, иддэг буурцаг, li:du: 绿豆 - ногоон өнгөтэй, жижиг мөхлөгтэй буурцаг, bada:mənēx 焖饭 - будаа агшаах, bada:mədēx 磨米 - будаа цайлгах, боловсруулах

Хоёр. Хорчин монголчууд тариалахын шалтгаанаас болж, айл тосгон төвлөрч, хүн ам ч олшрон, гэр бүлдээ хэдэн үеэрээ хамтран сууж, аж төрөн амьдрах болжээ. Энэ нь гэр бүлийн дотор үе зэргээ ялгаварлан дуудах шаардлагыг буй болгожээ. Ийм байдал доор хятадын нарийн ялгаварт төрөл садны дуудлага маш их тохирсноос, тэд шууд хэвээр нь зээлэн хэрэглэсэн байна. Жишээлбэл, ja:jə: 爷爷 - өвөг, nē:nē: 奶奶 - эмэг, da:ja: 大爷 - их авга, da:mə 大妈 - их авга эх, ʃu:ʃu: 叔叔 - авга, ʃinsə: 婶子- авга эх, gu:gu: 姑姑 - авга эгч, ʃu:ʃu 舅舅 - нагац аав, ʃu:mu: 舅母 - нагац эх, ʃə:ʃə: 姐姐 - эгч гэх мэтээр хятад дуудлагаар шууд нэрлэн дуудах нь олноос олон болов.

Энэ талын жишээ баримтыг эрвэл гарын аяар элбэг олдох бөгөөд цөөн бус хүн энэ тухай өгүүлэл зохиол бичиж, нийтэлснийг судалгааны байдлаас мэдэж болох тул, бид цаашид дэлгэн нуршихгүй. Дээрх хоёр бүлэг жишээнээс үзвэл, тариалах аж ахуй Хорчин аман аялгуунд үзүүлсэн нөлөөг бүрэн харуулж, тариалах соёлын онцлогоос болж, хятад зээллэг үг Хорчин монголчуудын өдөр тутмын амьдралд гүн нэвчсэн гэдгийг хүчтэй харуулж байна.

Суурьшил нь нэг талаар хүмүүсийн нийгмийн амьдралыг баяжуулдаг. Хорчин монголчууд суурин амьдралд шилжээд, аж үйлдвэр, арилжаа худалдаа, соёл сурган хүмүүжил зэрэг олон талаар харьцангуй хөгжсөн байна. Гэвч нөгөө талаар энэ нь

Хорчины хэл ярианд хятад зээллэг үгийн эзлэх харьцааг нэн түргэн нэмэгдүүлж, хятад зээллэг үг цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нэг талаар харамсалтай явдал юм.

Хоёрдугаар хэсэг.

Хятад зээллэг үг хорчин ардын урлаг соёлын хэлбэр өргөн хэрэглэгдсэн нь

Нэг. Хятад зээллэг үг Хорчин ардын дуунд өргөн хэрэглэгдсэн нь

Хятад зээллэг үг нь Хорчин ардын өдөр тутмын амьдралд гүн нэвчсэнээр барахгүй, Хорчин ардын дуунд ч өргөн хэрэглэгдсэн байна. Голдуу орон сууцын тухай хятад зээллэг үг, амьдралын хэрэгсэлтэй холбогдсон хоол будаа, ногоо цагаатай холбогдсон, тушаал, мэргэжлийн нэрс, төрөл садны дуудлагатай холбогдох хятад зээллэг үг болно. Иймэрхүү аж ахуй, нийгэм орчны нөлөөгөөр Хорчин ардын ярианд шингэсэн хятад зээллэг үг нь Хорчин ардын дуунд ч шингэн оржээ. Иймэрхүү жишээ маш олон, бараг Хорчин ардын дуу бүхэнд ор мөр олж болно. Бид энэ талын судалгаа, тоо нормын бүртгэлд өчүүхэн нэмэр болохыг хичээн чадахын хирээр цуглуулж авав.

(Нэг) Тариалан аж ахуйн шаардлагаас болж Хорчин монголчууд суурышаад, улмаар суурышихаасаа айл тосгон болж, гэр хүрээ байгуулах болжээ. Ингэснээс ардын яриа, ардын дуунд орон сууцын тухай нэг бүлэг хятад зээллэг үг орж иржээ. Доор эдгээр ардын дуунд хэрэглэгдсэн жишээнүүдийг үзье:

Уопэн 葛棚 гэрээ барих хүн чинь

У Уй Ганьсаар 杆子 юу хийнэ хүй

Чийрсэн пэн 棚-ээ барих хүн чинь

Чи Цунь 尺寸-аар юу хийнэ хүй

Үхэр цагт морджээ гээд

У Жя Зы 五家子-гийн хутунзи 胡同子-аар гүйж явна.

Уопэн/өвөн/ гэрийн чимэг чинь дээ,

Үүд болон цонх хоёр а ха хү хү хүй

Өөрийн биеийн тулгуур чинь дээ Ээж аав хоёул хүй

Шамфан 厢房 гэрийн чимэг чинь дээ

Цонх болон үүд л хоёр а ха хү хү хүй

Чухам биеийн тулгуур чинь дээ аав ээж хоёул хүй.

Хувилаг төрсөн Хандармаад хоргодож байсаар а хүй барчихжээ

Хоёр жан 间 гэр нь гал ортол мэдсэн ч үгүй,

Зүүн баруун биедээ жунлу 钟楼, гу лу 鼓楼-тай

Зурсан зургаан үсгийн их хоролтой

Зүйл бүрээр зохиосон Цигань 旗杆, пайлоу 排楼-тай

Зүг бүрийн сүсэгтэн залбирах мөргөлтэй,

Сайхан төрсөн сэнмэ ангаа хүй

Сансань 厢房 гэртээ ороод гиншиж байна хүй.

Эрт нэгэн цагт, Хорчин нутагт ядуу зүдүү нэг нь шавар гэр, өвсөн гэр, өвөн гэр, ма жя зы 马架子 гэр барих болсонд, баяд тарган нэг нь жунь 砖 - ий гэр, вааран 瓦 гэр барьж, бас түүнийгээ хүрээлэн хэдэн давхар үүд хаалга тааруулж, да мэнъ 大门, сяо мэнъ 小门, эл мэнъ 二门, гаргах болсон байна. Зарим гэрийнх нь хүн ам нэмэгдэн, мөн хамтдаа амьдрахын харгаагаар, гол байшингийнхаа хоёр хажууд чихэн, гэр шамфан

барих болсон бөгөөд цаашлаад олон өрх төвлөрөн айл тосгон болсоноос хутунзы, гай
街 ч буй болж, Хорчинчуудын дотор орон сууц, барилгын тухай хятад үгс аяндаа ардын
дуунд нь орж иржээ.

(Хоёр) Эдлэл хэрэгслийн тухай хятад зээллэг үг ч Хорчин ардын дуунд цөөнгүй
харагдаж байна. Жишээлбэл:

Болгосон төмрөө чамдаа тушаая хө хүй
Боодуу 博刀 хийнэ үү чиньдао хийнэ үү өөрөө мэд хүй,
Цэл ногоон алчуураараа тэргүүнээ ороожээ. Энэ охин хүй
Шилбэ болон товчоо дараад хундан бүс жан 丈 хоёр чи 尺 хүй.
Лан лангийн жүнз 盅 юүгээн гар гартаа өргөлцөөд э хэ хүй
Ламын хүрээний найраас илүү үзүүргүй их наргилджээ хүй.
Агаар тэнгэрийн нарыг гэрэлгүй гэж санаад хүй
Адал гэртээ өдрөөр дэн 灯, асааж сууна уу бид хүй
Эрдэнийн шанлү 香炉-даа хүжийгээ асаагаад хүй
Эвлэг бага Долгормаа чинь эцэг тэнгэртээ даатгаж байна хүй,
Дөрвөн хүний сы тай жяо 四抬轿-д нь сууж л үзжээ. мөмө ээ,
Дөрвөн гай дөчин хутунзаар тойрч үзжээ хүй,
Цагаан саарал илжиг минь дээ цаашаа чангаана вашидаа яаж вэ дээ
Цяньдайзы 钱袋子, үүрсэн дүвчин би даа урагшаа чангаана,
Хуопэнь 火盆-тэй гал дээр байх адил
Халуун ч дээрээ дулаан гутал аа хүй,
Урлаг төрсөн жимсийг алиа ч хэмээн сонслоо хүй
Улаан хэзы 盒子-тэй ха дэ мэнх 哈德门-ийг уулгаж баймаан дасгая хүй,
Таван хэлхээ түлхүүр чинь гэрийн эзэн хүй,
Тангүй 躺柜 дээр чинь сажилна гэрийн эзэн а ха а ха хүй,
Зургаан хэлхээ түлхүүр чинь гэрийн эзэн хүй,
Жюань гүй 卷柜 дээр чинь сажилна гэрийн эзэн а ха а ха хүй,
Зүүн шамфангаа барихын үед
Жунь болон тоосгоо зэрэглэж байгаад барьсан юм аа хүй
Өвсөн суо ии 蓑衣 хэдий муухай боловч хүй
Үүл гараад бороо орвол олдono уу да хүй,
Ху 壶-тай архинд нь согтуураад
Хурдан моринд нь ховдоглоод.

Энэ мэтээр Хорчин монголчууд суурьшин амьдарч, тариалан эрхлэн, хятад
үндэстний амьдрал үйлдвэрлэлийн эд хэрэгслийг хэрэглэж эхэлснээс, Хорчин ардын
дуунд ч боодуу, тангүй, жюань гүй, шэн 升, доу 斗, дань 担, дэн, дэнлүү 灯笼, хуу,
жүнз, шанлү, хэзы, суо ии зэрэг амьдралын хэрэгсэлтэй холбогдох хятад үг өргөнөөр
орж ирсэн байна.

(Гурав) Тариалан эрхлэхийг дагалдан мал маллахаа улмаар хаяж эхэлсэн Хорчин
монголчууд, мах идэхээсээ ногоо идэх болж, ногоо цагаа тарих, хуар цэцгээр хашаа
хүрээгээ чимэглэх, жич хятад үндэстний хоол будаа, ногоо зууш хийхийг ч сурсан
байна. Эдгээр амьдралын зан дадгалаас болж, Хорчин ардын дуунд мөн нэг хэсэг хятад
зээллэг үг шингэсэн юм.

Хуангуа 黃瓜 гээд тарьсан юм даа, ланьгуа 南瓜 суучихжээ

Хувраг хүнтэй явалцана гэдэг лаодао 唠叨 болчихжээ.
 Даландаа тарьсан да гуа 大瓜\
 Да гуаны сүмснийх нь амт аа
 Шандаа тарьсан шийгуа 西瓜
 Шийгуаны сүмснийх нь амт аа,
 Хүсч бахраад өгөөд тэгсэн хүргэн тун бао-г чинь хэлбэл а ха хө хүй
 Хөлдүү лууванг 萝卜 хөрвүүлж тавиад хөмсөг нүд харгачихжээ хүй,
 Боодуу саньдаогаа хавирч байгаад
 Банш 扁食, бууз 包子 идүүлэхгүй юу даа хүй,
 Лаажоу 辣椒 гэдгийг идсэнгүй болбол хүй
 Лаади 辣的-ийг яаж л мэднэ дээ хүй,
 Бор жороо морин дээрээ эмээлээ тохлоо хүй
 Бообо 饽饽 болон шаатан 砂糖-тайгаа багагүй ганзагаллаа хүй,
 Жалгандаа ургасан зуун өнгийн цэцэг хуар
 Жаазан 架子 доторх жаншлай хуарыг яаж ч гүйцнэ дээ
 Жоу чинь-ээс наашаа загуй охид байсан ч хүй
 Жян доу 豇豆 -гийн тариан дахь ганраймыг яаж ч гүйцнэ дээ хүй,
 Сянцай 香菜 ногоо нь шарлаж байна шүү жэдар на на хүй
 Ширээндээ юугаан тавья даа хайдар на на хүй,
 Сагагийн гурилаараа шарвингаа 馅饼 хайравч ээ
 Санаа тэндээ байна уу даа хө хө хүй,
 Сарвайж суугаад сяньзи 馅 юугаа дүгөөд хүй\
 Санасан чамайгаа дайлна шүү хүй,
 Урлаг төрсөн Циньцай 芹菜 хуар хүй
 Ургийн газартаа унжийн сууна хүй,
 Жимс гуозы 果子 -оо авчаад
 Жаахан хуарт мөргөв.

(Дөрөв) Ойр орчин үед, цаг төрийн үймээн дэвжээн, төр засгийн илжрэл доройтол, цэрэг засгийн үйл хэргээс болж, Хорчин ардын дуунд туаньжан 团长, суожан 所长, пайжан 排长, жинжан 警长, инжан 营长, жангүйда 掌柜的, мужян 木匠, жуаньжа 庄稼, шижян 石匠, сянь шэн 先生 зэрэг тушаал мэргэжлийн хятад үгс өргөнөөр хэрэглэгдэх болов. Жишээлбэл:

Зүүн хойт гурван зүгээр ан болон гөрөөг алдвал аа ха хүй
 Дорж жиича 稽查-гийн долоон пайжанг долоо долоо гуядана хүй,
 Найман хошууны Намсрай баньжан 班长,
 Нашоу 拿手-тай дээрээ нэмээстэй хүй\
 Арга бодлогоороо О тал заана балжийг ялгахгүй гээд хүй,
 Эмч болсон Мэнгүй дайфу 大夫 энэ үгийг сонсоод ээ
 Өвчүү болон цээжиндээ бодлоготой боллоо яа хүй
 Адал гэртээ эргээд харих сань инжан 三营长 чи сонс оо аа ха хө хүй
 Аав мөөмөөгийнхөө мэндийг нь мэдээд арваад хоновол харьж ирье хүй
 Эзний цэргийн инфан 营房-д суугаад өнгөрүү ч муухай уйдна хө хүй
 Өвчүү цээжинд уйтгарлах тул энүүгээр ирж тойрно хүй

Хойт айлын хурц хуажян 画匠-г залаад ирье маамаа нь хүй
 Хайрлаж санасан Вань ли чинийхээ хөргийг зуруулж авья хүй
 Аралт их тэргийгээ хөдөлгөчихжээ лаобаньзы 老板, 车夫 аа хүй
 Анга ч бага Вань Ли-гаа хүргээд гарчээ хүй
 Цуурынхаа толгойг хө хүй
 Шонхор мужаанаар хийлгэсэн юм, харанхуй шөнөдөө харуул манаатай
 Хас тамга олж хэмээн бодож байна уу гаозы нугууд хүй
 Ар дээр үүрсэн дэ чян пао минь үзэгдэхгүй нь таарна хүй
 Албан цэргийн дүй жан 队长 багш минь үлдээж авсан юм даа хүй
 Зүйтэй хүүхэн Линшигарвуу тоосноос нааш хүй аа ха нь яа хүй
 Зүрхээ автагдсан чэнсян 丞相-гаар нэрлэчихэв хүй
 Түвэгдээд заяасан газар орныг нь хэлбэл дээ хүй
 Түмэн цэргээ түрүүлсэн Ням туаньжангийн хороо хүй,
 Эд болон мөнгөө өгөөд авья гэлээ дээ хүй
 Эзний цэргийн Хад суожан болгох үгүйг яая да хүй
 Алаг хоёр нүд минь татаж байна хүй
 Албаны жанжин ирэх юм ба хүй,
 Лин суваргыг тахих хуушаан 和尚 шавьтай
 Ляо Ян хотын өмнө жүндүр байшинтай,
 Шүлэг бичиг аялуулсан нь хоцрон үлдэв
 Шивээ айлын Лао сяньшэн 老先生 шүлэглэн зохиов.
 Аавын нутагтаа байх лай хүй
 Адлаа хийсэн жуаньжя шүү хүй,
 Арван орны зайсян 宰相 боловч зэргээ хасагдвал
 Ард боолыг хүрнэ үү дээ хүй,
 Рө Хө/Жэхэ/ хотын зээлээр нь Хандармаа гарахлаар
 Ин цавчих шижян нарыг үзээд авчээ хүй
 Алим худалдах пүүзний 铺子 үүдээр Хандармаа гарахлаар
 Алим худалдах жангуйд нар нь алмайрчихжээ хүй.

(Таг) Хорчинчууд төрөл садны дуудлагадаа хятад нэрийдлийг зээлэн
 хэрэглэснээр барахгүй, бусад хамаа бүхий нэр дуудлага, цаашилбал хараал зүхээлийн
 үгэнд ч хятад зээлээг хэрэглэх болсон. Жишээлбэл, гүнж (公主), гуафү (寡妇), данжаад
 (当家的), гуангань (光棍), хунхууз (混混), сэ сүн (杂种), гаози (羔子), тооми (淘米) гэх
 мэт. Эдгээр үгс нь аяндаа Хорчин ардын дууг ч нөлөөлжээ. Жишээлбэл:

Таван настай хүүгийн минь нэр Сян Жинь Лун яа хүй аа ха нь яа хүй
 Нагац еэ еэ-гээ санасаар байгаад Сянсыбин (相思病)-тай болчихлоо хүй
 Долоон настай хүүгийн минь нэр Сян Мэй Рун яа хүй аа ха нь яа хүй
 Нагац найнай-гаа санасаар байгаад нас л юугаан барна хүй,
 Алтан дэлхийд алдартай алтан шаргыг арчилжээ та нар хүй
 Адуучин тооми бид хоёрыг ардаа хаясангүй нөхөрлөжээ хүй
 Өрх болон гэрт чинь энх байна уу аа жу жу ээ хүй
 Өтөлсөн есээ найнай-гийн эрдэнийн бие нь мэндхэн үү хүй,
 Аавынхаа үед юутай ч явав даа аа Тунлин хүй
 Аягын бухрыг малтаад явсан Жингар гуангань-ий үр чи хүй
 Сэтгэлээс санасан Сүй лин бид хоёрыг хүй

Са цунг чи хэлээд яаж л чадна даа хүй
 Түргэн зантай Үнэнбаяр Пао шоу хүй
 Өлзий гээгээгээ би одоо дагая гэлээ хүй,
 Асар лоу-гийн гөөгөө гэлээ амархан сууж байсан хүн биш шүү
 Ар өвөр хошуугаар нь агуу ч үймүүлжээ шүү аа ха хүй хө еэ яа,
 Адал болон гэртээ данжаад болсон болбол хүй
 Адуу малаа алаад тахилга тавьж өгнө хүй
 Ван гүнгийн охин гунян (姑娘) нь боловч
 Учирснаасаа салбал өрөөсөн шэ хүй
 Авга шү шү Тун Бао Лин-гийн гар дээр болоход гайгүй шүү аа ха гөөгөө хүй
 Авга Шэньсө ши юэ-ийн халыг яаж ч даая даа хүй,
 Авсан эхнэр Лин Ми минь ээ хө хүй
 Гуафу болоод хоцроно доо хүй
 Алтан асарын Лун бао дян-ийг байгуулсан газар аа хүй
 Анх бага Гао Сяо Же (高小姐)-гийн мэндэлсэн газар аа хүй
 Да мэнь дээр нь тулаад ирэх лай хүй
 Да еэ болон эл еэ (二爷)-гийн угтлагатай,
 Да мэнь үүд юүгээн өнгөрөөд ороод ирэх лай жинзүүрэм хүй,
 Да гунян (大姑娘) эл гунян (二姑娘) уйлж байна хүй
 Вангийн хүүхэн гүнж боловч хүй
 Ураглаж өгөх журамтай сая хүй,
 Да еэ болон да нян (大娘) - тайгаа хүй
 Өтлөө болсон хоёулаа хүй
 Жү жү болон жү мү-тай хүй
 Өтлөө болсон хоёул хүй
 Есөн төрлийн хожгир чи хүй
 И нян (姨娘) -гаа авах санаатай даа хүй,
 Залуу цэцэн Мөнгөнхуар
 Же жегийнхээ үгэнд орлоо шүү.

(Зургаа) Хорчин монголчууд хятад үндэстэнтэй хөршлөх буюу нийлэн сууж харилцаа явалцаа олширч, амьдрал үйлдвэрлэл илжирснээс зарим хятад нэр үгийг ардын дуундаа шууд хэрэглэх буюу хятад, монголыг холилдуулан хэрэглэх болсон байна. Жишээлбэл:

Алтан өдтэй гургалдайн донгодсон фэншуй 风水-г нь дарна гээд аа ха хүй
 Арван үетэй ширмэн суваргыг Шонхорын ууланд босгосон хүй
 Агт хүлгийн муугаар атаатны зулзагад дарлагдана шэ хүй
 Агт хүлэг сайн байсан бол эднүүсийн куй 亏-г иднэ үү дээ гээд хүй
 Эрээн гүнжи (公鸡) тахиа нь эхэлж дуугарахаас урьдаар хүй
 Өрхдөө байсан Заанаа балж өндийгөөд л бослоо доо хүй,
 Арван лангийн жао сян (照相)-г минь хүй
 Аргалын галд шатаачихлаа даа хүй
 Хавтгай цээжинд минь хэв гө ин (隔应) байна аа ха хө хүй
 Хар ч зулаг юугаан уях санаа ч үгүй лай хүй
 Өвчүү цээжинд минь вэб во нан (萸囊) байна аа ха хө хүй
 Өрх гэртээ ч суух сэтгэл үгүй лай хө хүй

Агт хүлэг морь минь арван түм байвч ээ хүй
 Алтан унаганы ма жю (马驹)-г гүйцнэ үү дээ хүй,
 Буувань түрийтэй жиньтоу (枕头)-гаа багахан Жиньсян дэрлэчихжээ хүй
 Бахрам төрсөн Жиньсян гул барууншаа хандаад хэвтлээ хүй,
 Ба юэ ши у (八月十五)-ийн өдөр нь болбол аа мөөмөө ээ
 Баруун Сю ууланд олон хүний цуглаа хүй
 Жю юэ жю (九月九)-ийн өдөр нь болбол ээ мөөмөө ээ
 Зүүн Сю ууланд олон хүний цуглаа хүй
 Зургаан ч пяодай (飘带) -тай уутыг чинь оёхлай хүй
 Зургаан сарын халуун нарандаа зовж байгаад оёсон юм аа хүй
 Лам ч галуу чинь дуугарч байна
 Лавдаад хуаннажээ (黄) ба би мэджээ.
 Таван өдрийн тариа минь дээ хө хүй
 Талын дундаа хуаннана (荒) даа хүй,
 Богдын сян гүн (相公) ноёнтон байсныг чинь мэдсэн бол
 Бороо цасанд нороод ирсэн бай да (白搭) болжээ хүй
 Да лам маам зоос л гээд нэхээд л байх лай вашидаа яанам хүй
 Дамар хонхоо дагнаж (当) байгаад өрийг чинь төлсөн хүй
 Боли (钹理) хүхэртэй бо хай (勃海) тамхиа бөглөртөл татна хүй
 Буулган өгөх Ваньлигаа бодвол бөглөрч таглараад байна хүй
 Саваагүй юманд савж дянъшигаад (颠) юу байна даа хүй
 Санаж бодсон үг байвал сайхан хэлэлцэе хоёулаа хүй
 Чандсаа үүрсэн Саримбуу гуйранч хүй
 Шанз (扇子) шанздаад (扇) гуаглаж байна даа хүй
 Ла сар (腊月) нь болбол хүй
 Ан ан эн
 Ламэй (腊梅) хуар нь дэлгэрнэ шүү
 Ан ан эн
 Үрлийн модны үеийн дээр хүй
 Эрвээхэй гэж бодоод байхлаар байлинзы (百灵) болжээ хүй
 Хөх торго гэгч хүрээний наймаа (买卖)-ны Дэмаа
 Хүсч дурлах сэтгэл бол Дэмаа чамд хүй
 Хайрласан аавынхаа алдарыг барж л болохгүй гээд хүй
 Хааны зарлиг гаоши (告示) бичгийг хаяан дээр чинь нааж уу даа хүй
 Чавгачин ээждээ мөргөнө гэж байсаар
 Саарал мориндоо мөргөчихөж шүү хүй
 Вааш да хуудуу (糊涂) болжээ хүй
 Хуангуа гээд тарьсан юм даа лангуа суучихжээ
 Хувраг хүнтэй явалцана гэдэг лаодао болчихжээ.
 Хүрдэт тэрэгний хөх луус (骡子)
 Хөдөөний замдаа жороо шүү дээ хүй
 Бадмын модных нь салааг нь дагаад
 Ба гэ (八哥) шувуу нь донгодолцоно хүй

Баруун шаньфангаа барихын үед
 Бань тэү болон тоосгоороо зэрэглэж байгаад барьсан юм аа хө
 Багахан линзийг олоод тэгэх үед аа ха хө хүй
 Бала (半拉) жилийн хүчээ оруулсан юм хүй
 Палан дундаа зогсвол хүй
 Пайчан (派场)-тай өлөгчин гэж хэлэгдэнэ хүй,
 Галзуурсан адил аашилж байгаа Навч чамайг аа хүй навч аа хүй
 Гай-ийн хятадад арилжжээ хэмээн бодьё мөөмөө нь ээ
 Маажан (麻将) шүйхо тэврэх нь дээ
 Малаа бас ч шүүгдэнэ (输) ба ?
 Жан нан (蟑螂) идсэн толгойн чинь хүй
 Зашуун үнэрийг нь яая даа хүй
 Өргөн их зээлийн дундуур Хандармаа гарахлаар
 Вэньжан (文章) бичиж байх дөрвөн сяньшэн үзээд авчээ хүй
 Энэ мэтчилэн хорчин ардын дуунд гао ши (告示), фэншүй, пайчан, пяодай сахуул
 (杂货), гуо тай (锅台), жаннан зэрэг үгс үргэлж яригддаг. Нэн сонирхолтой нь нэр үгээс
 гадна бас зарим үйл үгийг ч шууд зээлж монгол хэлний дагавар залгаад, хэлж дагуулах
 байдал Хорчин ардын дуунд харагдана. Жишээлбэл:
 “Гунан хүзүүт Намжил чи гуанах (管)-аасаа алдар даа
 Голдоо тоосон Юнрүв да ламтайгаа гуотай дээрээ залрая хүй” гэж “хамаарах” гэсэн
 монгол үгийг шууд “гуанах” гэж хятад үгээр авсан байна. Энэ мэтээр хуудуу, лаодао,
 дуйфүгээд (对), дуогээд (剁), цай цайлах (沏), хуан тан (荒唐), хуасан (花) зэрэг үйл
 үгст монгол хэлний дагавар залгах буюу монгол хэлний өгүүлбэрийн гишүүний
 байршлын ёсоор шууд хольж хэрэглэн дуулдаг байна. Жишээлбэл:
 Арав дуугарах сэлайтайгаа аюулхай дээр нь дүйлчихлээ (对) хүй
 Араар суусан Майдарын гэгээнийг бууж ирээ гээд л зандарчээ хүй
 Хувийн эр намайгаа гуанахгүй Жиньсян аа ха хө хүй
 Хааны цэргийн Данабалыг хартай санаж бэр чинь хүй
 Албан цэрэгтээ мордоод бие минь ах дүүгүй бэргэд сонс оо хүй
 Аягатай будаандаа зөвгүй тулд адлаа бэнж 奔着 иржээ хүй
 Алт гэдэг чинь дээ ховроос ховор оо данжаад аа хүй
 Адуу малаа хуавал олдог л юм аа аа хүй данжаад аа
 Эд гэдэг чинь чухлаас чухал аа аа данжаад аа
 Үхэр малаа гэвэл 豁 олдог л юм аа аа хүй данжаад аа
 Бараг төлөвийг нь үзээд хүй байчихья гэлээ дээ
 Ба ван эзэн У жан мөрөнд күнэгдчихсэн 困 өөр үү дээ
 Цэвэрхэн төрсөн Сэжид ангаа чинь
 Шитоу гөөгөө үзвэл сарвалзана
 Хэлэлцээгүй хоёулаа бөмбөрий
 Хуачуаньж 划拳 байгаад уучихья бөмбөрий
 Богд адил мэргэн хүн боловч хүй
 Буруу зөвийг олохгүй бол хуудуурч ирнэ хүй
 Эргүүлээд ороосон гэзэг чинь дээ хүй
 Аль ч бутанд нь гуагдаж 刮 бол даа?

Уруу царайтай хожгир чинь хүй
Үүсэн 捂 махны үнэртэй хүй
Дүйфүгээд сайхан амьдарья гэхлээр хүй
Дээр доор айлын доог шүү хүй.

Хоёр. Хятад зээллэг үг Хорчин ардын хэвимэл хэлцэд өргөн хэрэглэгдсэн нь

Хорчин ардын зүйр үг ба хавт үг урт удаан түүхтэй бөгөөд нийгмийн хөгжлийг дагалдан тасралтгүй хөгжсөөр ирсэн юм. Тэр нь хөгжлийн явцдаа тариалах аж ахуйтай холбогдсон үгс олширсноор барахгүй, нэн ялангуяа хятад зээллэг үг (голдуу нэр үг) өргөн хэрэглэгдэж, явах тутам өөрийн онцлог нь нэмэгдэж ирсэн байна. Жишээлбэл:

Албин чөтгөр хаана вэ?
Атар хээр намагт
Атаатан дайсан хэн бэ?
Алтан улсын Вань янь 完颜 овогтон
Усны хулу 葫芦
Тосны бүлүүр
Өргөн нутгийг хоосруулсан
Өшөөтөн дайсан У Чүн Шэн 人名,
Наалдвал салдаггүй цавуу гао яо 膏药
Наадаад ханадаггүй залуу нас
Хагархай цан 鏢 -ийн дуу нь муу
Ховч эмийн хоншоор нь муу
Хорчин нутгийг хоосруулсан
Хуйхар дээрэмч Жан Зо Линь (хүний нэр)
Хортой хүнд тус хийвэл
Хутганы үзүүр ган 钢 тавьсан мэт
Хөлдүү лууван 萝卜 царайлаад
Хөх дэлүүн зүслээд
Газар нутгаа хамгаалсан
Ганбү санбү-г дурсалтай
Гадаад дотоодод тэмцсэн
Гаадаа 嘎达 мэйрэний дуулалтай
Хүнийг хүнээр үзэхгүй
Коудай 口袋-г шуудайгаар үзэхгүй
Хүн байгаад бодлогогүй
Коудай байгаад амсаргүй
Гал түймэр хотонд гарахад
Гай 灾 гамшиг нуурын загасанд
Гаднаа түлээгүй,
Ган 缸 -даа усгүй,
Лам ламын уншлага нь асдаа
Лангуа, сяньгуа-ийн амт нь асдаа
Лууван авбал уг нь үлдэж
Лувсан үхвэл хүү нь үлдэнэ.
Шавраар босгосон хэрэм

Гурилаар нухсан боов,
 Тэнзэн модоор
 Тэнгэрийг тулж дийлэхгүй,
 Тэчиндалын нутаг даллага авдаг
 Овоо даран бүхнийг худалдаад
 Да ван 大王 ноёны шойшиг хатан
 Да янь татаж минчүүрнэ
 Дотроо мэдэж гаднаа гаргахгүй
 Үхрийн арьсан дэнлүү өнөд гэрэлгүй
 Цэцэг хуар хашааны чимэг
 Хүүхэд хүн гэрийн чимэг
 Чянь 钱-ээр цуглуулсан жин лан 两-аар гээх
 Чармайж олсноо чинээгээр бүрэлгэх
 Зааны зулзага доройтовч
 Зам дээр хэвтэхгүй
 Жанжны үр дийлэгдэвч
 Жадаа сүйтгэхгүй
 Илжгийн жил
 Луусын 骡子 хавар
 Илжгийг магтаад луус болгох
 Илжиг ч үгүй гурван лан 两 ч үгүй
 Унтвал урагшаа
 Утай 五台山-д очвол буян,
 Усан дээр тавьсан хулу,
 Бао гүн 包公 зөрүү хүү шиг
 Харанхуй шөнө дэн бариад олохгүй
 Коудайтайгаа хөнтрөөд шуудайтайгаа цутгах.
 Хулганыг магтаж луус болгох.
 Гахайн толгойг бариад Лао Е (老爷) - гийн сүмийг олохгүй.
 Гахайн торой азарган гахайд мэгжийн 母猪 дээр авирахыг зааж өгөх.
 Мах муу боловч манжингаас 蔓菁 дээр.
 Шайзанд 筛子 хийгээд тогтохгүй.
 Давсгүй наримын тан 汤.
 Зүүг цуглуулж зээтүү 镐头 болгох,
 Зээтүүг зүлгэсээр зүү болгох.
 Зүүдээрээ шарвин 馅饼 идэх.
 Ванг хожгороор гутаав.
 Вааран гэрийн тагтаа.
 Зүгээр суусан Жоу Зан /хүний нэр/ зүүний хэрэгт орсон нь.
 Хуудуу багшаас эндүү шавь.
 Хүнд хуудуу, биедээ хуудуугүй.
 Ган 干 жилийн зурам мэт.
 Мэргэн хүний хуудуу явдал хийх гэх мэт. Хавт үг, зүйр үг болон сэцэн үг бол нэг нийгмийн хэл хийгээд соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг болно. Хорчин аман аялгууны

хэвшмэл үг (хэлц) нь тариалах соёлын орчинд бүтээгдсэн нь илэрхий. Жишээлбэл: *Сайн хүн үг даана, Сагагийн гурил ус даана. Лайгийн доогуур ус гүйлгэх (далдуур хүнд муу хийх).* Зүүний үзүүрт цагаан будаа тогтоох (хүчир бэрх хэмээсэн үг) гэх мэт. Хэрэг юмыг зүйрлэхдээ *Хэнгэргэн дээр хар буурцаг цохих мэт* (хэл амандаа хурц), *Буурцгийн чинээ хөлсөн дусал, Сагагийн гурвалжин нүд*, гэж ургамал тариатай холбогдуулан дүрсэлдэг.

Гуравдугаар бүлэг.

Хорчин аман аялгуу дахь Хятад зээллэг үгийн монголжуу онцлог

Нэгдүгээр хэсэг:

Хорчин аман аялгуун дахь Хятад зээллэг үгийн авианы талын монголжуу онцлог

Хорчингууд Хятад зээллэг үгийг өөрийн хэл аялгуундаа авч хэрэглэхэд, Хорчин аман аялгууны авианы онцлог жам хуульд зохицуулан, нэлээд монголжуу болгосон байдалтай. Уул хятад үгийн ерөнхий ая дуудлага, эгшиг гийгүүлэгчийн системд хувирал үүсгэсэн нь, Хорчинчуудын авиалах заншил дүрэмд улам сайн зохицож, тухайн үгсийг үнэнхүү монгол зүс царайтай болгон өдөр тутмын харилцаандаа хэрэглэхэд дөхөм дөт болжээ.

Нэг. Ерөнхий ая дуудлагын талын монголжуу онцлог.

Хорчин аман зохиолын хятад зээллэг үгийн чухал нэг онцлог гэвэл уул хятад хэлний үгс нь утга ялгадаг дөрвөн аялгаа алдаж, бараг ганц аялгатай (нэгдүгээр аялга шиг) л үлджээ. Жишээлбэл: 辣椒 гэх үгийг хятад хэл дэх уул дуудлагаар là jiāo гэж авиалж байгаа биш, харин lāfu: гэж нэгдүгээр аялгаар гэж хэлэх үү, өргөлтгүй гэж хэлэх үү, бүр л нэг хэвээр ярьдаг байна. Хятад хэлний гуравдугаар аялгатай 姐姐 (jiě jie) гэх үгийг ч дээрхтэй адилаар бүр нэгдүгээр аялга буюу адил нэг хөгийн аястай фе: фе: гэж авиална. 酱油jiàng yóu гэх үгийг ч дээрхтэй нэг адил ёсоор авиалахаас биш хятад хэлнийх шиг дөрөвдүгээр ба гуравдугаар аялгаар авиалдаггүй юм.

Үүнийг Хятад, Монгол хоёр хэлний авианы чухал ялгаа зөрүүнээс болсон гэж хэлж болно. Дөрвөн аялга нь хэдийгээр Хятад хэлний үгсийн аль нэг авианд л холбогдсон явдал биш боловч дуудлага аяын талын утга ялгах үүрэг бүхий авиалбар болох тул, бид энэхүү онцлогийг авианы хэсэгт авч ярилцав.

Хоёр. Гийгүүлэгч авианы талын монголжуу онцлог.

1. Бидний мэдээжээр Хорчин аман аялгуунд “с” с гийгүүлэгч байхгүй. Монгол бичгийн хэлний “с” с авиаг Z “š”-р дууддаг заншилтай. Энэ зуршил нь Хорчингуудын хятад хэлнээс үг зээлэхэд нь ч адил үйлдэл үзүүлжээ. Жишээлбэл: Хорчингууд хятад хэлний 芹菜qíncai -г SieseI fínse: гэж, 三叉-г Seeza sanfa: гэдэг. 二齿子-г chǐ zǐ гэхийг F&Zw_ əfis гэж, 大擎da chǎng -г dezeit da:faŋ гээд, 拳头quán tyu-г SiyeedoO fəntu:dlx гэдэг нь үүний гэрч баримт болно. Ингэж монголжуу онцлогтой болон хувирч өөрчлөгдсөний учрыг сүвэгчилбэл, дээрх зурваст ярьсан шиг байж, Хорчин аман аялгууны уул авиан зүйн дүрэм зуршлаас болсон явдал л юм.

2. Хятад хэлний зарим үгийн эхний “n” гийгүүлэгч нь Хорчин аман аялгууны тохиролцсон үгэнд l гийгүүлэгчээр авиалагдаж байна. Хятад хэлний 粘粥niánzhōu -г liyeejoO, 粘粘的niōn niōn de Liyeeit liyeeit dI, 粘饽饽 liyeeit BoB, 泥板ní bǎn liyeebEeit, 南瓜nánguā leehgowa гэх мэтийн үгэн дэх粘niōn, 泥nn нь бүгд “n” гийгүүлэгч эхтэй байгаа боловч, эдгээр үгс нь Хорчин аман аялгуунд бүгд “l” гийгүүлэгч эхтэй дуудагдаж байна. Энэ бол Хорчин аман аялгууны авианы онцлогийн нэг тусгал юм. Учир нь нийт монгол хэл буюу бичгийн хэлний зарим үгийн эхний “n” гийгүүлэгчийг Хорчин аман аялгууны нэлээд үгэнд “l” гийгүүлэгчээр авиалдаг. Жишээлбэл: *морины ногт-морины логт, нүдний нуух-нүдний луух, модны навч, модны намаа-модны лавч, модны ламаа* гэдэг. Иймээс, Хорчингууд хятад хэлний зарим “n”-р эхэлсэн үгийг ч өөрийн авиалах заншлаараа “l” болгон авиачилдаг нь илэрхий байна. Яг иймээс Хорчин аман аялгуунд орсон дуудлагын талаар хувилбартай тэдгээр хятад зээллэг үгийг хятад хүн сонсоод ойлгохгүй боловч, Хорчин монголчууд сонсмогцоо тов тодорхой ойлголцдог байна.

Гурав. Эгшиг авианы талын монголжуу онцлог.

Дээрх бол Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үгсийн гийгүүлэгчийн талаас жишээлсэн явдал болно. Эгшгийн талаар ч монголжуу онцлогтой зүйл харагдаж байна.

1. Хорчин аман аялгуун дахь Хятад зээллэг үгсийг эгшгийн талаар шинжилж үзвэл доорх мэт онцлог мэдэгдэж байна.

粘粥 гэдэг үг нь хятад хэлэнд niánzhōu гэж авиалагдаж, 粥zhōu нь “ou” хос эгшиг бүтэцтэй байдаг. Энэ үг нь Хорчин аман аялгуунд орж ирэхдээ, 粘粥lənɬu: гэх хувилбар дуудлагатай болж уулын “ou” эгшгийн бүтэц нь “u:” урт эгшгийн бүтэцтэй болжээ. Энэ нь мөн л Хорчин аман аялгууны авианы хувирал хөгжлийн жам хуульд зохицсон үзэгдэл юм. Учир нь одоох Хорчин аман аялгуунд бичгийн хэлний хос эгшиг нь тохиролцсон урт эгшиг болон хувирсан бөгөөд Монгол хэлний бусад олонхи аялгуу, аман аялгуунд ч иймэрхүү хөгжлийн хандац буй.

Иймэрхүү жишээнээс дахин хэдийг дурдвал: 馒头mǎntou-г мантуу-mantu:, 酱油jiāngyóu-г жанюу-ɕaŋju:, 黄豆huángdòu-г хуандуу-xuāndu:, 笤帚tiáozhǒu-г тоожуу-tó:ɬu:, 瘦的shòu de, 臭的chòu de гэх хоёр үгийг шүүди-shu:di гэдэг.

2. Дээрхээс гадна хятад хэлний “ao, ai, ie” зэрэг хос эгшиг бүхүй үгс нь Хорчин аман аялгуунд зээлэгдэн орж ирэхдээ мөн авианы хувиралаар, тухайн үгс дэх хос эгшгүүд нь тус тус тохиролцсон урт эгшгүүдээр авиалагдах болжээ. Тухайлбал: 稻子dào zi-г dɔ:s, 包子bāo zi-г bɔ:s, 马勺mǎ sháo-г mɑ:ɬɔ:, 较量jiào liang-г ɕɔ:lɛŋlɛx, 讨米tǎo mǐ-г tɔ:mi:, 麦子mǎi zi-г mɛ:s, 酸菜suān cài-г suansɛ:, 奶奶nǎi nai-г nɛ:nɛ:, 太太tai tai-г tɛ:tɛ:, 姐姐jiě jie-г ɕɛ:ɕɛ:, 爷爷yéye-г jɛ:jɛ: гэдэг. Үүнд хятад хэлний хос эгшиг “ao” нь Хорчин аман аялгуунд “ɔ:”-оор, “ai” нь “ɛ:”-аар, “ei” нь “ɛ:”-ээр гэх мэтээр тус тусын тохирох урт эгшгүүдээр авиалагдаж байна. Энэ мэтээр Хорчингууд хятад хэлнээс үг зээлэхдээ, хэл аялгууны авианы хувиралын жам хуульд зохицуулж, зээлсэн үгсээ авиа дуудлагын хувьд улам эв тавтай монголжуу аятай болгон чадамгай ашиглажээ.

Үүнээс гадна, Хорчин аман аялгуун дахь Хятад зээллэг үгийн авианы хувьд монголжуу онцлогтой бусад зүйл зөндөө бий боловч, энд тэр бүхнийг нэгд нэггүй тоочихыг товчлоё.

Хоёрдугаар хэсэг:

Хорчин аман аялгуун дахь Хятад зээллэг үг зүйн бүтцийн монголжуу онцлог

Аль нэг хэлэнд харь хэлнээс үг зээлэхэд, тэрхүү хэлний авиаг эх хэлний авиа зүйн онцлог жам хуульд зохицуулан, авиа дуудлагын хувьд ямар нэгэн хэмжээгээр хувиргадаг бол, үгзүйн хувьд ч адил жам ёс үйлдэл үзүүлдэг. Бодтойгоор хэлбэл, зээллэг үгийг үгзүйн бүтэц хэлбэрийн талаас шинжин үзвэл, уул хэл дэх үгс нь зээлэгсдийн эх хэлний үг бүтээх ёс, үг хувилалын заншил дүрэмд захирагдан, мөн энэ хэлний хэлбэр бүтцийн шинжтэй болж хувирдаг юм.

Нэг. Үйл үгийн хувьд:

Хорчин аман аялгууны хятад зээллэг үгсийн үгзүйн бүтцийн хувьд авч үзвэл, хятад хэлний үгийн язгуур буюу үндсэнд монгол хэлний дагавар, нөхцлийг залгаж бүтсэн нь зонхилох тоог эзэлж буй. Иймэрхүү үгст голдуу үйл үг илүү холбогдож байх шиг. Гэхдээ хятад хэлний үйл үгийн язгуурт монгол хэлний үйл үгийн олон хувиралын нөхцлийг залгаж болох боломжтой бөгөөд Хорчин аман аялгууны нэлээд олон хятад зээлээ үйл үгс иймэрхүү аргаар бүрэлдэн тогтов.

1. Хорчин аман аялгуунд, *-qu/-кь, -γda/-gde, -γul/-гьл, -γsan/-gsen, -day/-deg, -γsaya/-gseger, -čü/-čü, -γad/-ged, -baču/-bečü, -bal/-bel, -jei* гэх мэтийн үйл үгийн нөхцлийн аль нэг нь буюу аль нэг хоёрыг угсруулан залгаж болох үүсмэл хятад зээллэг үгс нэлээд буй. Жишээлбэл: Хятад үгийн үндэс монгол хэлний дагавар буюу нөхцөл залган бүтсэн үгс: 管 *guǎn* - гуаних, гуаньсан, гуаньдаг, гуаньсаар, гуаньж, гуаниулах, гуанигдах, гуаньжээ ...

干 *gān* – ганих, ганьсан, ганьдан, ганьсаар, ганьж, ганиулах, ганьжээ...

拌 *bàn* – баних, баньсан, баньсаар, баньж, банивч, баньжээ...

炖 *dùn* - дүнэх, дүнсэн, дүнсээр, дүнэвч, дүнжээ...

焖 *mēn* – мэнэх, мэнэсэн, мэнэсээр, мэнэж, мэнэвч, мэнэжээ...

2. Хорчин асан аялгуунд хятад хэлний нэг бүлэг үйл үгийн үндсэнд монгол хэлний үйл үг бүтээх - *le / - la* дагаврыг залгаж, үүсмэл зээллэг үг бүтээн хэрэглэсэн жишээ илүү тоотой байна. Жишээлбэл: хятад үгийн үндэс – монгол хэлний – *le* дагаврыг залгаж бүтсэн үгсийн жишээ:

赔 *péi* – *пэйлэгдэх* - энэ өдөр хантааз аваад пэйлэгджээ гэх мэт

碰 *pèng* – *пэнлэх, пэнлэн* - тэр хүнтэй ас пэнлэх гэх мэт

对 *duì* – *дүйлэх, дүйлэн* – хоёрыг дүйлж үзэх гэх мэт

挡 *dǎng* – *данлах, данлан* – явах замыг данлах гэх мэт

垛 *duò* – *дуолох, дуолон* – өвс дуолох гэх мэт

劈 *pī* – *пийлэх* – мод пийлэх гэх мэт

赊 *shē* – *шэлэх, шэлэн* – зоосгүй хүн шэлэх дуртай гэх мэт

租 *zū* – *зуулах, зуулах* – хямдхан гэр эрж зуулах гэх мэт

坑 *kēng* – *кэнлэх, кэнлэн* – хүнийг кэнлэх зантай гэх мэт

赶趟 *gǎntàng* – *ганьтанлах* – одоо гаравч ганьтанлахгүй лэй гэх мэт

Хоёр. Тэмдэг үгийн хувьд:

Хорчин аман аялгуунд нэг хэсэг –di төгсгөл бүхий хятад зээлээ тэмдэг үг идэвхтэй хэрэглэгдэж байна. Жишээлбэл:

Хятад үг – Хорчин аман аялгуу дахь дуудлага жишээ:

忙的 māng de- манди – өдөртөө ман манди яараад... гэх мэт

扁的 biǎn de – бянди – бянь бянди болтол дарах гэх мэт

奸的 jiānde – жяньди – тэр чинь жяньди хүн, чиний арганд орохгүй гэх мэт

烂的 lān de- ланьди – ланьди майтай юмыг бүү ид гэх мэт

掘的 jué de- жүэди – илжиг адил жүэди гэх мэт

碎的 suǐ de- суйди – бүтэн байсан юм суй суйди болж хагарчээ гэх мэт

光滑的 guāng huá de - гуан гуанди гялайтал зүлгээд гэх мэт

白白的 bái bái de- байбайди – ам өвдтөл байбайди хэлжээ, үг сонсох үг ангаа гэх мэт

要紧的 yào jǐn de – яожиньди – лоо яожиньди учиртай, хурдан ирдээ гэх мэт

甜的 tián de- тяньди - 咸的 xián de – сяньди, 辣的 là de – лади, 酸的 suān de – суаньди – тяньди, лади, суаньди янзын амттай юм байна гэх мэт.

Нэлээд тооны Хорчин хүмүүс дэргэдэх хятад зээлээ тэмдэг үгийг өндөр нормтой хэрэглэж, уул монгол хэлний тохиролцсон тэмдэг үгийг хэрэглэхгүй буюу хэлж чадахгүй болсон байдалтай.

Гурав. Цаг хугацааны нэрийдлийн хувьд:

Хорчин аман аялгуунд, үндсэн тооны үгэнд хятад хэлнээс үг зээлсэн байдал харагдсангүй. Гэвч цаг хугацааны нэрийдэлд хятад зээллэг үгийг авч хэрэглээд, доор нь монгол хэлний тийн ялгалын нөхцлийг шууд залгаж ярих нь олонтаа. Жишээлбэл: *гурван цагт очих - сандянь-лай(дуга-гийн хувилбар) очих, Долдугаар сард амралт болно – Чи юэ фэнь-ээс фанжяна, арван сарын нэгний үед нэг гараг амарна – Ши и-гийн үед нэг шинчи амарна* гэх мэтээр хэлж ярих нь олон. Үндсэн тооны үг буюу хэрэг юмны тоо хэмжээг заах үес, ер нь хятад зээллэг үгс хэрэглэдэггүйгээр онцлогтой.

Нарийн шинжилбэл, дээр дурдсанаас гадна Хорчин аман аялгуу дахь хятад зээллэг үгийн үг зүйн хэлбэр бүтцийн хувьд, монголжуу онцлогтой зүйл бас олон байгаа нь мэдээж. Гэвч бид түр хугацаанд тэр бүхнийг хураангуйлж амжаагүй байна Хойшид бололцоо байвал энэ талаар илүүхэн анхаарч шинжмээр санагдаж байна.

Дүгнэлт

Үг зээлэх асуудал бол нийгмийн асуудал юм. Тэр нь үг зээлэгч тухайн үндэстний онцгой нийгэм түүх, соёл, орчин ахуйгаас шалтгаалан аяндаа болох явдал юм. Тэр нь ямар нэгэн улс төрч, авъяас чадвартан эсвэл аль нэгэн хүч нөлөө бүхий хэсэг бүлэг хүмүүс дур зоргоор үүсгэж үйлдсэн үйл хэрэг, үр дүнг огт биш. Хорчины ард түмэн хэдэн зуун жилээр бусад монголчуудынхаа зүүн хилээр аж төрөн амьдран оршиж, газар нутгаа алдах аюул болоход, Гаадаа мэйрэн шиг эр баатар эсэргүүцэн тэмцэж, амь биеэ ч үрэгдүүлж байжээ. Энэ нь Хорчин нутгийн ойр орчин үеийн өвөрмөц түүхэн ахуй байдлаас болсон явдал юм.

Хорчингууд иймэрхүү өвөрмөц нийгэм түүхэн хувьсал жич амьдран оршоо онцгой соёлын орчин ахуйгаас болж, өөрийн хэл аялгуундаа хөрш зэргэлдээ үндэстний үг хэл бүхий холимог соёлт аж амьдралаа үргэлжлүүлж буй.

Зээлдэж орж ирсэн хятад зээллэг үгс нь Хорчингуудын өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгдэх болсноор барахгүй, тэдний урлаг соёлын хэлбэрт ч шингэн нэвчиж, өвөрмөц хөг ая нэмэгдсэн элбэг баялаг аман зохиолын бүтээлд үйлчилж байна. Бидний ажигласнаар, хятад зээллэг үг хорчин ардын аман зохиол, хэвшмэл хэлцэд нэвчин шингэж, хорчин ардын өвөрмөц үнэр амт бүхий урлаг соёлын хэлбэрийг бүрэлдүүлсэн тухай хэлний талаас шинжилсэн өгүүлэл зохиол арай харагдаагүй байсаар. Иймээс тус хэсгийг бид шинээр анхаарч шинжилсэн зүйл гэж үзэж байна. Яриангүй энэ талын ажлыг соёл хэлшинжлэлийн үүднээс улам шинжлэх ухаанчаар судалж шинжлэх чухалтай.

Хорчин аман аялгуун дахь хятад зээллэг үгс нь Хорчин аман аялгууны авиа бүтцийн онцлог жам хуульд захирагдан, монголжуу үнэр амт нэмэгдэн, өдөр удах тутам Хорчин ардын хэл ярианд уусан шингээд үргэлжлэн үйлчлэх болно. Хорчин аман аялгууны Хятад зээллэг үгсийн “Монголжуу онцлог”-той болгосон гэдэг нь бидний өгсөн анхны нэрдэл дуудлага байжээ. Шинжлэх ухаанч оновчтой нэрс болж чадаагүй магад. Ямар ч болтугай зээллэг үг ба зээлсэн хэлний хоорондох авиа, үгзүйн ижилшил буюу ойролцоо хувьсал нь зээллэг үгт хэл бүхэнд байх ерийн хууль жам болохоор энэ талын хэлний үзэгдлийг илүүхэн анхаарч судлах нь хэл шинжлэлийн онол аргын ач холбогдолтой гэж бид үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. bayančoγtu, (2002) *qorč'in aman ayalγun-u sudulul*, öbür mongγol-un yeke surγayuli-yin keblel-ын qoriy-a.,
2. tedke, qayirqan, erdemtū, sodu, (2001) *qorč'in aman ayalγu ba oron nutuγ-un soyul sudulul*, liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a.,
3. tulyayuri, b.sodu erkilen nayirayuluγsan, (2008) *qorč'in aman ayalγun-u qubiral kōgjil-ün sudulul*, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.,
4. bayančoγtu, (2007) *nutuγ-un ayalγun-u sinjilel*, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.,
5. kürelša, (2003) *qorč'in jang üile-yin soyul sudulul*, öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a.,
6. qurča, čang ming, (2001) *qorč'in tobč'iyān*, ündüsüten-ü keblel-ün qoriy-a.,
7. qaserdeni nar, (2006) *mongγol yariyan-u kele jūi*, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.,
8. sečen erkilen nayirayuluγsan, (1998) *mongγol kelen-ü nutuγ-un ayalγun-u sinjilel*, töb-ün ündüsüten-ü yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a.,
9. sečēnbayatur erkilen nayirayuluγsan, (2008) *mongγol kelen-ü nutuγ-un ayalγun-u sinjilel-ün uduridqal*, öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.,
10. 查干哈达 (1996) 《蒙古语科尔沁土语研究》, 社会科学文献出版社.,
11. 双山 (2004): 《蒙古语科尔沁土语词江研究》, 中央民族大学博士学位论文.,
12. 素德 (2005): 《蒙古语科尔沁土语中的汉语借词》, 《民族语文》, 第5期.,
13. e.kesigtū, (1989) *qorč'in aman ayalγun-u jarim ončaliγ-un tuqai ögülekü ni*, // öbür mongγol-un ündüsüten-ü baysi-yin degedū surγayuli-yin erdem sinjilegen-ü ögülel.,
14. sečēnγow-a, ürgün, öljeisayiqan nar emkidken čuylayulba, (1987 on-u 4 sar-a) *qorč'in arad-un dayuu “nige”*, öbür mongγol-un soyol-un keblel-ын qoriy-a.,

15. sečenyow-a, ürgün, nar emkidken čuyayulba, (1987 on-u 5 sar-a) *qorčın arad-un dayuu "qoyar"*, öbür mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a.,
16. sangdai, (2005 on-u 4 sar-a) *qorčın arad-un jüir üge ba qabutu üge-yin emkidkel*, öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.,
17. mandul-a, (2001 on-u 12 duyar quyučay-a) *qorčın arad-un dayuu daki kitad kelen-ü nölügelel*, // "mongyol kele bičig" sedkül.,
18. b.sodu, (2001 on-u 8 duyar quyučay-a) *tariyalaqu soyul ba qorčın ayalyu*, "mongyol kele bičig" sedkül.,
19. ü. erkimbayar, (2003 on-u 3 duyar quyučay-a) *qorčın-u yajar usun-u ner-e-yin domuy daki kitad soyul-un nölüge*, // öbür mongyol-un ündüsüten-ü yeke suryayuli-yin erdem sinjilegen-ü ögülel.,
20. b.sodu, (2005 on-u 6 duyar quyučay-a) *qorčın soyul sudulul-du qolbuydaqu jarim asayudal*, öbür mongyol-un neyigem-ün sinjilekü uqayan.,
21. qasbayatur, (2002 on-u 5 duyar quyučay-a) *mongyol kelen-deki kitad jigelege üge-yin asayudal-du*, // "mongyol kele bičig" sedkül.,
22. zandan, (2008 on-u 4 düger quyučay-a) *neyigem kele sinjilel-ün qarayan-ača qorčın aman ayalyun daki mongyol kitad qolimay kelelge-yin bui boluysan siltayan-i sübegčilekü ni*, // öbür mongyol-un neyigem-ün sinjilekü uqayan-u erdem sinjilegen-ü ögülel.,

SUMMARY

Loanwords depend on society, history, culture and habitat of a borrower-country itself. In case of Khorchin dialect, which has been under strong influence from Chinese words that not only feel pressure from everyday dialogues but also from oral literature and even phrases, it needs a critical study within cultural linguistics.